

Захиргааны хэм хэмжээн
актын улсын нэгдсэн сан
2018. оны 06. сарын 25-и
едрийн 389 дугаар бүртгэ



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн дүрэм батлах тухай


Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1."Анагаах ухааны Ёс зүйн хяналтын хороо, салбар хорооны үлгэрчилсэн
дүрэм"-ийг нэгдүгээр, "Шинжээчийн үнэлгээний загвар хуудас"-ыг хоёрдугаар
хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг мөрдөж ажиллахыг анагаах ухааны сургалт, судалгаа, эрдэм
шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эрдэм шинжилгээний хүрээлэн,
их, дээд сургууль, тусгай мэргэжлийн төвийн /дарга, захирал нар/-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж
ажиллахыг Эм, үйлдвэрлэл технологийн газар/Д.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны 223
дугаар, 2013 оны 485 дугаар, 2014 оны 29 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд
тооцсугай.



000075

Эрүүл мэндийн сайдын 2018 оны 25 дугаар сарын 30-ны өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт 17

АНАГААХ УХААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРОО, САЛБАР ХОРООНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь шинжлэх ухаан, үйлдвэрлэл, техник технологийн хөгжил, хүний сайн сайхны төлөө гүйцэтгэгдэж байгаа, хүн, амьтныг оролцуулан хийх био анагаах, тархвар зүйн судалгаа, ажиглалт, туршилт шинжилгээний үед хүн, амьтны эрхийг хамгаалах, шинжлэх ухааны ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ёс зүйн хяналтын хороо, салбар хорооны үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Анагаах ухааны сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, тусгай мэргэжлийн төвийн дэргэд анагаах ухааны ёс зүйн салбар хороо, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо тус тус ажиллана. Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо, салбар хорооны үндсэн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна.

1.3. Ёс зүйн хяналтын хороо, салбар хороо нь судалгаа, туршилт, эрдэм шинжилгээний төслийг үнэлэх, анагаахын шинжлэх ухааны ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихдаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Технологи дамжуулалтын тухай хууль, Хог хаягдалын тухай, Амьтны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Олон улсын гэрээ, Хельсинкийн тунхаглал (WMA,2014), хүнийг хамруулсан био-анагаахын судалгааны удирдамж (CIOMS,2002), Тархвар зүйн судалгааны ёс зүйн хяналтын олон улсын удирдамж (CIOMS,2010), 4R зарчим (туршилтын амьтны ёс зүй) зэрэг анагаах ухааны болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Ёс зүйн хяналтын хороо, салбар хорооны бүтэц бүрэлдэхүүн, баримтлах зарчим, үйл ажиллагааны чиглэл, санхүүжилт

2.1. Бүтэц, бүрэлдэхүүн:

2.1.1. Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороо, салбар хороо нь 7-13 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулна.

2.1.2. Хорооны дарга, гишүүн, нарийн бичгийн даргыг 6 жилийн хугацаатай томилно. Хорооны гишүүн, дарга, нарийн бичгийн дарга хүндэтгэн үзэх

шалгаантай буюу өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх тохиолдолд томилгоог нөхөх, сольж болно

2.1.3. Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны дарга, нарийн бичгийн дарга гишүүдийг сонгон шалгаруулах ажлыг тусгайлсан ажлын хэсэг /комисс зохион байгуулж, хяналтын хорооны бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.1.4. Ёс зүйн хяналтын салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх анагаах ухааны ёс зүйн хяналтын хороотой зөвшилцэн, энэхүү журмын 12-т заасан байгууллагын дарга /захирал/ томилно.

2.1.5. Ёс зүйн хяналтын хороо, салбар хорооны бүрэлдэхүүнд олон талт төлөөлөл буюу анагаах ухааны салбарын эрдэм шинжилгээний туршлага бүхий эрдэмтэн, судлаач, эмнэлгийн мэргэжилтэн, хуульч, шашны төлөөлөгч нарыг оруулна. Мэргэжлийн болон үйл ажиллагааны чиглэлийг харгалзан төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оруулж болно.

2.1.6. Ёс зүйн хяналтын хороо, салбар хороо нь энэхүү үлгэрчилсэн дүрэмтэй нийцүүлэн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн эрх, үүрэг, хурлын дэг, үйл ажиллагааг тусгасан өөрийн дүрмээ боловсруулан баталж, мэрдөнө

2.1.7. Ёс зүйн хяналтын хороо, салбар хороо нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Хорооны үйл ажиллагаа, судлаачийн судалгаа, шинжилгээ, туршилт явуулахтай холбоотой баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу тухайн байгууллагынхаа архивт тодорхой хугацаагаар хадгалуулна.

2.2 Баримтлах зарчим:

2.2.1. Хороо нь Монгол Улсын нутаг дэвсгэрт анагаах ухааны чиглэлээр хийгдэх судалгаа, шинжилгээний төсөл, туршилтад зөвшөөрөл олгоходоо дараах үндсэн зарчмыг баримтлана. Үүнд:

- Үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чийнээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүйгээр хүний эрхийг дээдлэн, энэрэнгүй байж, хүний нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн, эрх тэгш байдлыг хангах;
- Шударга ёсыг баримтлах;
- Судалгаа нь хүний сайн сайхан, эрүүл мэндийн төлөө, тодорхой чиглэлтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй, үр ашигтай байх;
- Биологийн олон янз байдлыг хамгаалах;
- Судалгаа, эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг хамрагдаж буй хүний хүсэл сонирхол, албан ёсны зөвшөөрлийн үндсэн дээр явуулах;
- Амьтныг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах;

2.3. Үйл ажиллагааны чиглэл, хэлэлцэх асуудлын хүрээ:

2.3.1. Хяналтын хороо нь дор дурьдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулж, хэлэлцэнэ. Үүнд:

- Олон улсын хамтарсан судалгаа;

- Шинжлэх ухааны суурь болон захиалгат, цөм технологи, инновацийн судалгаа;
- Анааах ухааны судалгааны ёс зүйн удирдамж боловсруулан баталж, гарын авлага гаргах;
- Анааах ухааны судалгааны ёс зүйн удирдамжийн дагуу судлаач нарт сургалт зохион байгуулах;
- Эрдмийн зөвлөлийн баталсан арга аргачлалыг хэлэлцэх;
- Судлаачийн ёс зүйн асуудал.

2.3.2. Салбар хороо нь дор дурьдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулж, хэлэлцэнэ. Үүнд:

- Судлаач нарт судалгааны ёс зүйн сургалт зохион байгуулах;
- Магистр, доктор, баклаврын түвшингийн болон бусад судалгааны ажил, төсөл, хөтөлбөр;
- Судлаачийн ёс зүйн асуудал.

2.4. Санхүүжилт:

2.4.1. Хорооны гишүүдийн урамшуулал, үйл ажиллагааны зардлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, анааах ухааны сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, тусгай мэргэжлийн төв нь тухайн жилийн байгууллагынхаа төсөв, гадаадын зээл тусламж, төсөл, хөтөлбөрт тусгах байдлаар санхүүжүүлнэ.

Гурав. Анааах ухааны ёс зүйн хяналтын хорооны эрх, үүрэг

3.1. Эрх:

3.1.1. Анааах ухааны ёс зүйн хяналтын хороо нь дор дурьдсан эрхтэй.

- Салбар хороог байгуулах;
- Холбогдох хууль, журам болон үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн хяналтын хорооны үйл ажиллагааны дүрмийг батлах;
- Судалгааны ажилд зөвшөөрөл олгох, хянах, дүгнэлт гаргах; түтгэлзүүлэх, зогсоох;
- Эмнэлзүйн туршилт судалгаа, шинжилгээний ажилд таниулсан зөвшөөрөл өгөх;
- Шинжээч томилох;

3.2. Үүрэг:

3.2.1. Дор дурьдсан үүрэгтэй.

- Судалгаанд оролцогчийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалах;
- Анааах ухааны ёс зүйн удирдамж батлах, түүний дагуу сургалт зохион байгуулах;
- Судалгааны ёс зүйн удирдамжийг боловсруулан, баталж, салбар хороодод хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

- Судалгааны арга аргачлал, баримт бичгийн нууцлалыг задруулахгүй байж, хорооны гишүүд, шинжээч нараас нууцлалыг чанд хадгалж задруулахгүй байх баталгаа гаргуулах;
- Судалгааны зөвшөөрөл олгох шийдвэрийг кодлох ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Анагаах ухааны ёс зүйн салбар хорооны эрх, үүрэг

4.1. Эрх:

4.1.1. Анагаах ухааны ёс зүйн салбар хороо нь дор дурьдсан эрхтэй:

- Судалгааны ажилд зөвшөөрөл олгох, хянах, дүгнэлт гаргах, түдгэлзүүлэх, зогсоох;
- Эмнэлзүйн туршилт судалгаа, шинжилгээний ажилд таниулсан зөвшөөрөл өгөх;
- Салбар хороо нь үйл ажиллагааны дүрмийг үлгэрчилсэн дүрэмд нийцүүлэн боловсруулж, батлах;
- Судлаач нарт судалгааны ёс зүйн сургалт зохион байгуулах, арга зүйгээр хангах, зөвлөгөө өгөх;
- Магистр, доктор, баклаврын түвшингийн болон бусад судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд судалгааны ёс зүйн зөвшөөрөл олгох, хянах, дүгнэлт гаргах;
- Шинжээч томилох;

4.2. Үүрэг:

Дор дурьдсан үүрэгтэй.

- Судалгаанд оролцогчийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эрхийг хамгаалах;
- Судлаачийн судалгаа, шинжилгээ, туршилт явуулах зөвшөөрөл хүссэн судалгааны баримт бичгийн нууцлалыг задруулахгүй байх;
- Жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан үйл ажиллагаагаа ёс зүйн хяналтын хороонд тайлагнах;
- Анагаах ухааны хяналтын хорооны баталсан судалгааны ёс зүйн удирдамжуудыг баримтлах;

Тав. Шинжээчийн эрх, үүрэг

5.1. Эрх:

- Судалгааны ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Судалгаатай холбоотой нэмэлт мэдээлэлийг судалгааны багаас авах;
- Судалгааны баг, судлаач нарт зөвлөгөө өгөх.

5.2. Үүрэг:

- Судалгааны хяналтын болон салбар хороонд судалгаатай холбоотой ёс зүйн хороо санал өгөх;
- Судалгааны ажилд үнэн, зөв, дүгнэлт гаргах;
- Судалгааны багт зөвлөмж хүргүүлэх.

Зургаа. Хариуцлага

- 6.1. Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ;
- 6.2. Шинжээч өөрийн гаргасан дүгнэлтийг бурэн хариуцна;
- 6.3. Шинжээчид нөлөөлөхийг хориглоно.

908744-Оо--8 1116126518

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
дугаар сарын 50-ны өдрийн 12 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

05

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС /загвар/

Нэг.Шинжээчийн мэдээлэл

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр:	Нэр:
Регистрийн дугаар:		
Ажиллаж байгаа байгууллага:		
Албан тушаал:		
Шинжлэх ухааны салбар, мэргэшсэн чиглэл:		
Холбоо барих утас:		
И-мейл хаяг:		

Хоёр.Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Судалгааны төслийн шинжээчээр ажиллаж байгаа (овог
нэр) миний бие өөрийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг
үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

- Тухайн судалгааны төслийн удирдагч болон багийн гишүүдтэй ах дүү, төрөл садан,
багш шавь, наиз нөхдийн холбоогүй.
- Тухайн судалгааны төслийн багт орж ажиллаагүй.
- Бусад

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

20... оны-р сарын-ны өдөр

Гурав. Үнэлгээ

Нэг. Төслийн Ерөнхий мэдээлэл

1.1.	Төслийн нэр:			
	Төслийн төрөл	Тохиорх төслийн төрлийг √ тэмдэглэнэ үү. <input type="checkbox"/> Суурь судалгааны сэдвэтийн ажил <input type="checkbox"/> Шинжлэх ухаан технологийн төсөл <input type="checkbox"/> Инновацийн төсөл <input type="checkbox"/> Цөм технологийн төсөл <input type="checkbox"/> Докторын дараах судалгааны тэтгэлэг <input type="checkbox"/> Гадаадтай хамтарсан төсөл <input type="checkbox"/> Шинжлэх ухааны академийн грант <input type="checkbox"/> Залуу судлаачдын грант		
1.2	Санхүүжилтийн хэлбэр	<input type="checkbox"/> Яамдын эх үүсвэр – яамны нэрийг бичих <input type="checkbox"/> Шинжлэх ухааны технологийн сан <input type="checkbox"/> Гадаадын эх үүсвэр <input type="checkbox"/> Орон нутгийн эх үүсвэр <input type="checkbox"/> Дотоодын хандив <input type="checkbox"/> Бусад		
1.3	Хэрэгжих хугацаа	Эхзлэн: (он, сар)	Дуусах: (он, сар)	
1.4	Судалгааны төсөл хэрэгжүүлэгч	Нэр: Байгууллага: Байршил: Төслийн удирдагчийн нэр: Төслийн багийн бүрэлдэхүүн:		

ХОЁР. БҮРДҮҮЛСЭН МАТЕРИАЛЫН ҮНЭЛГЭЭ:

№	Жагсаалт	Байгаа эсэх ✓	Дүгнэлт /тайлбар бичнэ/	Дэмжиж байгаа эсэх /тайлбар/
2.1.1	Анагаах ухааны ёс зүйн шаардлага хангасан эсэх			
2.1.1	Эмнэлгийн шине багаж, хэрэгслийн судалгааны хяналт			
2.1.2	Судалгааны багийн гишүүд дашиг сонирхлын зөрчилтэй эсэх			
2.1.3	Судалгааны хяналтын маягыг ашиглах дахин өргөсөн судалгааны аргачлалын хяналт			
2.1.4	Судалгааны аргачлалд оруулсан нэмэлт өөрчлөлтийн тухай			
2.1.5	Судалгааны аргачлалын явцын хяналт			
2.1.6	Төгсгөлийн тайланг хянах			
2.1.7	Судалгааны аргачлалаас гажих зөрчихэд авах арга хэмжээ			
2.1.8	Судалгаанд хамрагдагсадын зүгээс тавих хүсэлтийг шийдвэрлэх			
2.1.9	Судалгааны явцтай газар дээр нь танилцах			
2.1.10	Ноцтой гаж урвал (НГУ)-ын тайланг хянах			
2.1.11	Судалгааны багт ёс зүйн зөрчилтэй гишүүн байсан эсэх			
2.1.12	Материалын танилцуулга			

2.1.13	48 асуулт бүхий арга зүй			
2.1.14	Гадаадтай хамтарсан болон гадаад санхүүжилттэй судалгааны арга зүй бүрэн орчуулагдсан гэрээ түүнд тусгагдсан ёс зүйн асуудлууд			
2.1.15	Эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл			
ГУРАВ. Таниулсан зөвшөөрлийн хуудас				
3.1	Хувь хүний таниулсан зөвшөөрөл			
3.2	Таниулсан зөвшөөрөл авах. Судалгаанд хамрагсад өгвэл зохиц мэдээлэл			
3.3	Таниулсан зөвшөөрөл авах. Судлаач болон ивээн тэтгэгчийн үүрэг			
3.4	Судалгаанд оруулан санаа төрүүлэх			
3.5	Судалгааны оролцсоны ашиг тус ба эрдэл			
3.6	Таниулсан зөвшөөрөл өгөх чадваргүй оролцогчийг судалгаанд хамруулсан тохиолдолд эрсдэлд тавих зарим хязгаарлалтууд			
3.7	Орлогто багатай хүн ам ба нийгмийн бүлэг дэх судалгаа			
3.8	Эмнэл зүйн туршилтанд хяналтын бүлгийг сонгох			
3.9	Эмзэг бүлгүүд			
3.10	Судалгаанд хамрагсадыг сонгоход эрдэл, ашиг тусыг тэнцүүлэх			
3.11	Эмзэг бүлгийнхнийг хамруулсан судалгаа			
3.12	Хүүхдийн хамруулсан судалгаа			
3.13	Сэтгээчин болон зан үйлийн эмгэгийн улмаас таниулсан зөвшөөрөл өгөх чадваргүй хүмүүсийг хамруулсан судалгаа			
3.14	Судалгаанд эмэгтэйчүүдийг хамруулах			
3.15	Нууцлалын баталгаа			
3.16	Гэмтэл авсан хамрагсадын эмчлүүлэх нөхөн олговор авах эрх			
3.17	Ёс зүйн болон эрдэм шинжилгээний хяналт фианагаахын судалгааны чадавхийг нэмэгдүүлэх			
3.18	Эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд судалгааг санхүүжүүлэгчийн ёс зүйн үүрэг			
3.19	Туршилтын амьтантай харьцах ёс зүйн удирдамж			
3.20	Төслийн багийн чадамж.			
3.21	Шинжлэх ухаанч байдал			
3.22	Таниулсан зөвшөөрлийн хуудас аргачлалын дагуу шалгана/			
3.23	Эмнэлзүйн туршилт судалгаа			
3.24	Хог хаягдал			
3.25	Бусад			

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ




4.1. Төслийн зорилго, зорилтууд
(Судалгааны мониторингийн карт,
гэрээний хавсралт болон тайлангаас харна уу)

Төслийн зорилго:

Зорилт 1.

Зорилт 2.

Зорилт 3.

4.2	Төслийн үр дүнгийн үзүүлэлтүүд (Гэрээний 1-р хавсралтаас харна уу)	Үр дүн 1. Үр дүн 2. Үр дүн 3.																																							
4.3	Явцын гүйцэтгэл (Судалгааны мониторингийн карт, тайлангаас харна уу)	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: center;">Төлөвлөсөн ажлууд</th> <th style="text-align: center;">Хугацаа (он, сар)</th> <th style="text-align: center;">Хүрсэн үр дүн</th> <th style="text-align: center;">Дундаж үнэлгээ (0-100%)</th> </tr> </thead> <tbody> <tr><td>Үйл ажиллагаа 1:</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>Үйл ажиллагаа 2:</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>Үйл ажиллагаа 3:</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>Үйл ажиллагаа 4:</td><td></td><td></td><td></td></tr> <tr><td>Үйл ажиллагаа 5:</td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	Төлөвлөсөн ажлууд	Хугацаа (он, сар)	Хүрсэн үр дүн	Дундаж үнэлгээ (0-100%)	Үйл ажиллагаа 1:				Үйл ажиллагаа 2:				Үйл ажиллагаа 3:				Үйл ажиллагаа 4:				Үйл ажиллагаа 5:																		
Төлөвлөсөн ажлууд	Хугацаа (он, сар)	Хүрсэн үр дүн	Дундаж үнэлгээ (0-100%)																																						
Үйл ажиллагаа 1:																																									
Үйл ажиллагаа 2:																																									
Үйл ажиллагаа 3:																																									
Үйл ажиллагаа 4:																																									
Үйл ажиллагаа 5:																																									
4.4	Хэрэгжилтийн талаарх дүгнэлт: Зөвлөмж: Зөвлөгөө:																																								
4.5	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th rowspan="2" style="width: 25%;">Батлагдсан төсөв:</th> <th colspan="2" style="width: 25%;">Он</th> <th colspan="2" style="width: 25%;">20...</th> <th colspan="2" style="width: 25%;">20...</th> </tr> <tr> <th style="text-align: center;">Олгогдсон</th> <th style="text-align: center;">...</th> <th style="text-align: center;">...</th> <th style="text-align: center;">...</th> <th style="text-align: center;">...</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="2" style="text-align: center; vertical-align: middle; padding-left: 10px;"> Зардлын ангилал  </td> <td style="text-align: center; vertical-align: middle;">Эзлэх дээд хязгаар</td> <td style="text-align: center; vertical-align: middle;">Төслийн төрөл</td> <td style="text-align: center; vertical-align: middle;">Гадаадтай хамтарсан төсөв, %</td> <td style="text-align: center; vertical-align: middle;">Төслийн төрөл</td> <td style="text-align: center; vertical-align: middle;">Гадаадтай хамтарсан төсөв, %</td> <td style="text-align: center; vertical-align: middle;">Шинжээч</td> </tr> <tr> <td style="text-align: center; vertical-align: middle;">Зарчулалтын байдал</td> <td style="text-align: center; vertical-align: middle;">Төслийн төрөл</td> </tr> </tbody> </table> <p style="text-align: center;">Төсөв, санхүүжилтийн мэдээлэл</p> <p style="text-align: right; margin-right: 10px;">9087443 УХА0578 1116126516</p>	Батлагдсан төсөв:	Он		20...		20...		Олгогдсон	Зардлын ангилал 	Эзлэх дээд хязгаар	Төслийн төрөл	Гадаадтай хамтарсан төсөв, %	Төслийн төрөл	Гадаадтай хамтарсан төсөв, %	Шинжээч	Зарчулалтын байдал	Төслийн төрөл	Төслийн төрөл	Төслийн төрөл	Төслийн төрөл	Төслийн төрөл	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 25%;">Төслийн гэрээт ажилтны хэлс, НДШ, ХАОАТ</th> <th style="width: 25%;">Гадны байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр</th> <th style="width: 25%;">Гадаад дотоод томилолтын зардал</th> <th style="width: 25%;">Тоног төхөөрөмж ашиглалтын засвар үйлчилгээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Төслийн гэрээт ажилтны хэлс, НДШ, ХАОАТ</td> <td>Гадны байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр</td> <td>Гадаад дотоод томилолтын зардал</td> <td>Тоног төхөөрөмж ашиглалтын засвар үйлчилгээ</td> </tr> <tr> <td>Их сургуулийн лаборатори, судалгааны туршилтын бааз, багаж, тоног төхөөрөмж ашигласны шимтгэл</td> <td>Бусад зардал</td> <td>Мэдээлэл худалдан авах, Социологийн болон түүвэр судалгааны зардал</td> <td>Эрдэм шинжилгээний хурал,</td> </tr> </tbody> </table>			Төслийн гэрээт ажилтны хэлс, НДШ, ХАОАТ	Гадны байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр	Гадаад дотоод томилолтын зардал	Тоног төхөөрөмж ашиглалтын засвар үйлчилгээ	Төслийн гэрээт ажилтны хэлс, НДШ, ХАОАТ	Гадны байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр	Гадаад дотоод томилолтын зардал	Тоног төхөөрөмж ашиглалтын засвар үйлчилгээ	Их сургуулийн лаборатори, судалгааны туршилтын бааз, багаж, тоног төхөөрөмж ашигласны шимтгэл	Бусад зардал	Мэдээлэл худалдан авах, Социологийн болон түүвэр судалгааны зардал	Эрдэм шинжилгээний хурал,
Батлагдсан төсөв:	Он		20...		20...																																				
	Олгогдсон																																				
Зардлын ангилал 	Эзлэх дээд хязгаар	Төслийн төрөл	Гадаадтай хамтарсан төсөв, %	Төслийн төрөл	Гадаадтай хамтарсан төсөв, %	Шинжээч																																			
	Зарчулалтын байдал	Төслийн төрөл	Төслийн төрөл	Төслийн төрөл	Төслийн төрөл	Төслийн төрөл																																			
Төслийн гэрээт ажилтны хэлс, НДШ, ХАОАТ	Гадны байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр	Гадаад дотоод томилолтын зардал	Тоног төхөөрөмж ашиглалтын засвар үйлчилгээ																																						
Төслийн гэрээт ажилтны хэлс, НДШ, ХАОАТ	Гадны байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр	Гадаад дотоод томилолтын зардал	Тоног төхөөрөмж ашиглалтын засвар үйлчилгээ																																						
Их сургуулийн лаборатори, судалгааны туршилтын бааз, багаж, тоног төхөөрөмж ашигласны шимтгэл	Бусад зардал	Мэдээлэл худалдан авах, Социологийн болон түүвэр судалгааны зардал	Эрдэм шинжилгээний хурал,																																						

семинар үзэсгэлэн, олон улсын хурал зохион байгуулах зардал /эмхтэл хэвлүүлэх, хурлын заалны түрээс, бичиг хэргийн зардал г м/					
Гадаадын эрдэмтэн судлаачдыг Монголд байх хугацааны үйлчилгээний зардал Орнуулгын болон дээж авчрах, шинжлүүлэх зардал Ном, бүтээлийн хэвлэлийн эх бэлтгэл, судалгааны ажлын тайлан бичихтэй холбогдсон зардал, патентийн болон гишүүнчлэлийн төлбөр/ тухайн судалгааны ажилтай холбогдох/ Урвалж бодис, микроорганизм ёсгөвөр угамлын үр сорт худалдан авах зардал					
Туршилтын мал амьтан худалдан авах, устгаж аюулгүй болгох зардал Сэлбэг хэрэгсэл, лабораторийн хэрэгсэл худалдан авах зардал					
Компьютерийн программ хангамж зохиох, худалдан авах, засвар үйлчилгээ хийлгэх зардал					
Хэдэлмөр хамгааллын зардал Туршилтын цех, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдан авах зардал /төрийн өмчийн хорооны шийдвэр/					

---oo---